



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 18

УАГ-ТАГ/2017/02-ГА

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараахь зөрчил илэрлээ. Үүнд:

Баян-Овоо сумын Соёлын төв 138,0 мянган төгрөгийн үнэтэй принтер 1ш, Номгон ахлах сургууль 1210,0 мянган төгрөгийн 10 ширхэг өлгөдөг самбар, Баянговь сумын сургууль 1128,4 мянган төгрөгийн 40 ширхэг сандал, 1485,0 мянган төгрөгийн 20 ширхэг ширээ, Баянлиг сумын сургууль 1974,7 мянган төгрөгийн 70 ширхэг сандал, 2598,7 мянган төгрөгийн 35 ширхэг ширээ, Богд сумын дунд сургууль 8901,5 мянган төгрөгийн физикийн лабораторийн тоног төхөөрөмж, Баянцагаан, Бууцагаан, Эрдэнэцогт, Баян-Өндөр, Баянговь, Гурванбулаг, Жинст, Шаргалжуутын дунд сургуулиуд Шинэ зуун боловсролын төслийн хүрээнд нийлүүлсэн 2805 ам.долларын үнэтэй/2805\$\*2450төг=6872250 төг/ 61850,0 мянган төгрөгийн 9 ширхэг электрон самбар, Баянговь, Өлзийт сумын дунд сургууль 1230,0 мянган төгрөгийн суурин компьютер 2 ширхэгийг, нийт 81746,7 мянган төгрөгийн хөрөнгийг орлого аваагүй, тайлан балансад тусгаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын 6.1 "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусах хүртэл, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч бүртгэн санхүүгийн тайландаа тусгана" гэсэн заалтыг зөрчсөн байна.


Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-р "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх", Монгол

2517005

улсын Ерөнхий аудиторын 2016.09.09-ний өдрийн А/95 тоот тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй" алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

Нэг. Хавсралтад заасан 81746,7 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагуудын хөрөнгийн бүртгэлд орлого авахуулах.

Хоёр. Зөрчлийг арилгаж, баримтыг 2017 оны 05 дүгээр сарын 15-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга М.Мөнхбат-д даалгав.


|                    |                                                                                     |                          |
|--------------------|-------------------------------------------------------------------------------------|--------------------------|
| АЛБАН ШААРДЛАГЫГ   |                                                                                     |                          |
| ӨГСӨН <sup>2</sup> |                                                                                     |                          |
| АУДИТОР<br>ШИНЖЭЭЧ |   | Б.АЗБАЯР<br>Б.ЦЭРЭНЧИМЭД |
| ЗӨВШӨӨРСӨН:        |                                                                                     |                          |
| ДАРГА              |  | М.МӨНХБАТ                |

0416221019  
2016.09.09

<sup>2</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас төлсөн албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын бодлууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцаж албан тушаалтанд хариуцлага нэвдүүлэхөөр эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

№ 18. албан шаардлагын хаялралт

| д.д | Байгууллагын нэр                 | Хөрөнгийн нэр                   | Нэгж үнэ  | тоо | Бүтд үнэ   |
|-----|----------------------------------|---------------------------------|-----------|-----|------------|
| 1   | Баян-Овоо сумын Соёлын төв       | Принтер /Хөгсх/                 | 138,000   | 1   | 138,000    |
| 2   | Баянговь сумын дунд сургууль     | Сурагч ширээ                    | 74,250    | 20  | 1,485,000  |
|     |                                  | Сурагч сандал                   | 28,211    | 40  | 1,128,440  |
|     |                                  | Ширээний компьютер /хү бүрдэл/  | 1,230,000 | 1   | 1,230,000  |
|     |                                  | Электрон самбар 2805 ам.доллар/ | 6,872,250 | 1   | 6,872,250  |
| 3   | Баянлиг сумын дунд сургууль      | Сурагч ширээ                    | 74,250    | 35  | 2,598,750  |
|     |                                  | Сурагч сандал                   | 28,211    | 70  | 1,974,770  |
|     |                                  | Электрон самбар 2805 ам.доллар/ | 6,872,250 | 1   | 6,872,250  |
| 4   | Номгон ахлах сургууль            | Самбар /өлгөдөг/                | 121,000   | 10  | 1,210,000  |
| 5   | Богд сумын дунд сургууль         | Физикийн лаборатори             | 8,901,512 | 1   | 8,901,512  |
| 6   | Өлзийт сумын дунд сургууль       | Ширээний компьютер /хү бүрдэл/  | 1,230,000 | 1   | 1,230,000  |
| 7   | Баянцагаан сумын дунд сургууль   | Электрон самбар 2805 ам.доллар/ | 6,872,250 | 1   | 6,872,250  |
| 8   | Бууцагаан сумын дунд сургууль    | Электрон самбар 2805 ам.доллар/ | 6,872,250 | 1   | 6,872,250  |
| 9   | Эрдэнэцогт сумын дунд сургууль   | Электрон самбар 2805 ам.доллар/ | 6,872,250 | 1   | 6,872,250  |
| 10  | Баян-Өндөр сумын дунд сургууль   | Электрон самбар 2805 ам.доллар/ | 6,872,250 | 1   | 6,872,250  |
| 11  | Гураванбүлэг сумын дунд сургууль | Электрон самбар 2805 ам.доллар/ | 6,872,250 | 1   | 6,872,250  |
| 12  | Жинст сумын дунд сургууль        | Электрон самбар 2805 ам.доллар/ | 6,872,250 | 1   | 6,872,250  |
| 13  | Шаргалжуутын дунд сургууль       | Электрон самбар 2805 ам.доллар/ | 6,872,250 | 1   | 6,872,250  |
|     |                                  |                                 |           |     | 81,746,722 |

Аудитор  Б.Азбаяр  
Шинжээч  Б.Цэрэнчимэд



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 12 УАГ-ГАГ/2017/02-ГА

Номлон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шаргалжуут тосгоны эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч "Алтайн газрын хүч" ХХК-ийн 2016.10.20-ны өдөр гаргасан ажлын гүйцэтгэлээр нийт ажлын 73% хийгдсэн гэж санхүүжилтийг авсан ба аудитын явцад объект дээр очиж ажиллахад гүйцэтгэлээр гаргасан ажлуудаас Хаалга цонхны ажил 32.1 сая, гадна дотор заслын ажил 44.1 сая, Гадна усан хангамжийн бохирын ажил 17.9 сая, Гадна дулааны ажил 49.4 сая, бохирын цооногийн ажил 28.6, гадна цахилгааны ажил 3.1 сая, Дотор цахилгааны ажил 40.4 сая төгрөгийн нийт 215.6 сая төгрөгийн ажлууд хийгдээгүй байхад гүйцэтгэлийг баталгаажуулж санхүүжилтийг олгосон, гэрээний хугацаа 2016.12.31-ний өдөр дууссан байхад нийт ажлын 47 хувь буюу 516.0 сая төгрөгийн ажил хийгдээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 290 тоот тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журмын 3.3-т заасан "Захиалагч байгууллага ... ажлын батлагдсан зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр нь тулган шалгаж, баталгаажуулна" Монгол улсын Иргэний хуулийн 350.1.1-д "гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-р "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх", Монгол улсын Ерөнхий аудиторын 2016.09.09-ний өдрийн А/95 тоот тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1.5-д "Байгуулсан гэрээ,


2517007

хэлцэл мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага, нөхцлийг хангаагүй” гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

Нэг. Гэрээний хугацаанд хийгдээгүй 516.0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлж улсын комиссоор хүлээн авч, ашиглалтад оруулах.

Хоёр. Зөрчлийг арилгаж, баримтыг 2017 оны 08 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга Г.Батжаргал, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Ихбаяр, аймгийн ГХБХБГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Норов нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ  
ӨГСӨН<sup>2</sup> :

|                                                    |                                                                                      |              |
|----------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------|--------------|
| АУДИТОР                                            |     | Б.АЗБАЯР     |
| ШИНЖЭЭЧ                                            |     | Б.ЦЭРЭНЧИМЭД |
| ЗӨВШӨӨРСӨН:                                        |                                                                                      |              |
| АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА                                |  | Г.БАТЖАРГАЛ  |
| АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО |  | Д.ИХБАЯР     |
| ТӨЛӨВЛӨТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН      |  | Т.НОРОВ      |
| ГҮЙЦЭТГЭГЧ                                         |                                                                                      |              |
| ГХБХБГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ      |                                                                                      |              |

<sup>2</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдсаныг тогтоолголд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас нэвчсэн албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг уурзал ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага нэгдүүлэхээр эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 20 УАГ-ТАГ/2017/02-1А

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн зөрхийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гурванбулаг сумын Сургуулийн засварын ажлын 48.4 сая төгрөг, Хүрээмарал сумын Сургуулийн засварын ажлын 64.8 сая төгрөгийн ажлыг хөрөнгийн бүртгэлд сайжруулалтаар бүртгээгүй байна.


Энэ нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын 6.1 **"Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусах хүртэл, худалдан авсан тоног төхөөхөмжийг ашиглалтад хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч бүртгэн санхүүгийн тайландаа тусгана"** гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-р "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх", Монгол улсын Ерөнхий аудиторов 2016.09.09-ний өдрийн А/95 тоот тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй" алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

Нэг. Бүртгэлд тусгаагүй 113.2 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагуудын хөрөнгийн бүртгэлд орлого авахуулах.

2517099

Хоёр. Зөрчлийг арилгаж, баримтыг 2017 оны 05 дугаар сарын 15-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга М.Мөнхбат-д даалгав.

|                    |                                                                                                                            |              |
|--------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|
|                    | <div>АЛБАН ШААРДЛАГЫГ<br/>ӨГСӨН² :</div>  | Б.АЗБАЯР     |
| АУДИТОР<br>ШИНЖЭЭЧ |                                          | Б.ЦЭРЭНЧИМЭД |
|                    | <div>ЗӨВШӨӨРСӨН:</div>                    | М.МӨНХБАТ    |
| ДАРГА              |                                          |              |

<sup>2</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байдгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаа хувицаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ахлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байдгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харууцаан албан тушаалтанд харууцлага нэгдүүлэхээр эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 24 УАТ-ТАГ/2017/02-ТА

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн зөрхийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. "Базардарь" ХХК-ийн гүйцэтгэсэн Шаргалжуут тосгоны цагдаагийн кабоны ажлыг ашиглагч байгууллага чанар, ашиглалтын байдал хэвийн, гэж албан бичиг ирүүлсэн боловч аудитаар газар дээр нь очиж шалгаж үзэхэд Шаргалжуут тосгоны кабоны паркетан шал хэмжээ алдаж шахсанаас дээшээ хөндийрч, хөөсөн байдалтай, дотор тал 1 хаалга хаагдахаа больсон, цонхны ойр орчин цантаж мөстсөн.

2. "Елбата"ХХК-ийн гүйцэтгэсэн "Баянговь" сумын дунд сургуулийн их засварын ажил нь ашиглалтын явцад вакум цонхны завсраар салхи сийгэх, хаалганы нугас салж унах, спорт залны цонхны доод хэсгийн хана нурах, цуурах, коридорын дүүжин тааз бэхэлгээнээсээ унасан.

3. "Елбата"ХХК-ийн гүйцэтгэсэн Гурван булаг сумын дотуур байрны их засвар нь паркетан шалны өнгө зарим газраа хуурч, хөндийрч салсан, таазны замаск хуурч унасан, хаалгануудын нугас, бариул цоож, эвдэрсэн, цонхны гадна талын шавар ховхорч унасан, хаалга хуучин рам дээр суугдсан, амалгаа шавар нурсан, зарим тасгуудын гэрлийн унтраалга эвдэрсэн.

4. "Хоролбагана Констракшн" ХХК-ийн гүйцэтгэсэн Баянбулаг сумын 10 ортой эмнэлгийн барилгын ажлыг хүлээн авахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэргэнцрийн замыг стандартын дагуу болгох, шатаах зуух өндөрлөх, эмчийн өрөөний цонхны гадна шаврыг нөхөж бөглөх, агааржуулалтын систем ажиллуулах, зарим паарны ус алдалтыг зогсоох, мооргийн өрөө, складайн дотоод засварыг гүйцээх, гадаад тохижилтын ажлыг бүрэн гүйцээж хийх, хог хадгалах байр барих 8 төрлийн үүрэг даалгавар өгснийг хэрэгжүүлээгүй байна.

2517011

Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"-ын 3.23-т "Барилгын чанарын баталгаат хугацаа Барилгын тухай хуульд заасан хугацаа 3 жил байх бөгөөд энэ хугацаанд байгалийн болон давагдашгүй нөлөөнөөс бусад шалтгаанаас үүдэн барилга байгууламжид эвдрэл гэмтэл гарвал гүйцэтгэгч байгууллага захиалагчийн эхний шаардлагаар үнэ төлбөргүй засварлана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-р "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх", Монгол улсын Ерөнхий аудиторын 2016.09.09-ний өдрийн А/95 тоот тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1.7-д "... үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

Нэг. Чанар муу хийсэн дээрх ажлуудын зөрчлийг арилгаж 2017 оны 06 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн ГХБХБГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Норовт даалгав.

АУДИТОР  
ШИНЖЭЭЧ



Б.АЗБАЯР  
Б.ЦЭРЭНЧИМЭД

ЗӨВШӨӨРСӨН  
АЙМГИЙН ГХБХБГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Т.НОРОВ



<sup>2</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангавдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд хариуцахаа нэгдүүлэхөөр эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.